



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

164 /164/

2021.10.26

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО




Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай БНСУ-ын Сөүл хотноо 2021 оны 10 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Сөүлийн агаар сансар, батлан хамгаалахын олон улсын үзэсгэлэн” /ADEX-2021/-нд оролцлоо. Энэ үеэр дэд сайд Б.Баярмагнай зарим улсын батлан хамгаалах аж үйлдвэрийн төлөөлөгчидтэй уулзав.

Мөн тэрээр БНСУ-ын Үндэсний Батлан хамгаалахын

дэд сайд Пак Жэ Минтэй уулзаж, хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтынажиллагааны талаар ярилцаж, санал солилцов. Хоёр улсын Батлан хамгаалахын дэд сайд нар цэргийн хамтарсан сургууль, цэргийн боловсон хүчний сургалт, солилцооны үйл ажиллагаа тасралтгүй ахиж байгааг өндрөөр үнэлж, цаашид цэргийн өндөр түвшинд харилцааны идэвхтэй хандлагыг хадгалж, хоёр орны стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, цэргийн харилцааг улам бэхжүүлэхийн төлөө хамтран ажиллахаа илэрхийлжээ.

“ADEX-2021” нь сансар судлал болон батлан хамгаалахын дэвшилтэт техник хэрэгслийг дэлгэн үзүүлж, бүс нутгийн орнуудын дэвшилтэт техник технологитой танилцах, мөн оролцогч талуудад хоёр талын уулзалт хийж, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх боломжийг олгодог олон улсын индэр болж байна.



Түүхэнд энэ өдөр

1934 он:

МАХЦ-ийн Жанжин штабын даргаар Ж.Малж томилогджээ. Тэрээр Жанжин штабын анхны монгол дарга болжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 9	☁️ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,850.0	2,853.0
EUR 🇪🇺	3,315.0	3,325.0
CNY 🇨🇳	445.0	446.0
RUB 🇷🇺	39.90	41.60
JPY 🇯🇵	24.76	25.31
KRW 🇰🇷	2.34	2.47

ЗУРХАЙ

2021.10.26 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 21/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.28-17.45

Барилдлага:

Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Төрөн түгэхүй
Суудал:
Огторгуй

Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, агуул үйлдэх, мал худалдан авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ОЛОН СЭДВИЙГ ХӨНДСӨН ЦУГЛАРАЛТ БОЛЖ БАЙНА



Радиотехникийн анги, салбаруудын тусгай зориулалтын техникуудийн ашиглалт, чанар байдлыг дээшлүүлэх аргачлалыг боловсронгуй болгох нь сэдэвт цугларалт энэ сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдана.

Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсээс явуулж байгаа уг цугларалтад радиолокацийн үндэс, түүний ашиглалт, орчин үеийн РЛС-уудын ашиглалтын онцлог, засвар үйлчилгээ хийх аргачлал, тоон систем, автоматжуулалтын өнөөгийн байдал зэрэг олон сэдвийг хөндсөн илтгэлүүд хэлэлцэгдэх ажээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
350,604 +1095

ЭДГЭРСЭН
530,687

НАС БАРСАН
1,593 +6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5914 +102

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
249

ЭДГЭРСЭН
5552

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 244,802,162

Эдгэрсэн

Нийт: 221,935,396

Нас барсан

Нийт: 4,969,861

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 338 ДУГААР АНГИЙГ Ч.ДАНЗАН ГЕНЕРАЛЫН НЭРЭМЖИТ БОЛГООСОЙ



Өнөөгийн жаргалант амьдралын төлөө амь хайргүй тэмцэж явсан, өнөөдрийн Зэвсэгт хүчний хөгжил дэвшил, улс ардын аж ахуйд бодитой хувь нэмрээ оруулсан Төр, цэргийн нэртэй зүтгэлтнүүдээ хойч үедээ алдаршуулах нь хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил олгоход туйлын их тустай гэж үздэг хүмүүсийн нэг нь би билээ. Харин сүүлийн жилүүдэд

эл үзэл бодол багагүй урагштай байж, хурандаа генерал Б.Цог, Ж.Ёндон, С.Равдан, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж, Ш.Жадамба зэрэг цэргийн нэртэй дарга, жанжидаа мөнхжүүлэн, цэргийн заримангийг тэдний нэрэмжит болгосоны отгон нь хэдхэн хоногийн өмнө Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийг

хошууч генерал, агсан Ч.Самбуугийн нэрэмжит болгосон нь юутай их бахархал билээ. Тэгвэл, дайны хүнд жилүүдэд дайчин баатарлаг цэргүүддээ ухуулга сурталчилгааны ажлыг чадмаг зохион байгуулж, ялалтыг наашлуулахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан хийгээд, энх цагийн бүтээн байгуулалтад улс

орныхоо хөгжил дэвшилд мөн л үнэлж баршгүй хувь нэмрээ оруулж, олон арван барилга байшин, үйлдвэр завод, сургууль цэцэрлэг, сангийн аж ахуй байгуулахад нойр хоолоо умартан зүтгэж явсан нэгэн бээрийг мартаж болохгүй сэн. Миний хувьд тойм төдий л зүйл дурдлаа. Энэ хүний тухайд бүхэл бүтэн ном товхимол бүтээгээд ч хязгаарлагдахгүй. Биднээсээ холдон одоод олон жилийн нүүрийг үзэж буй энэ хүнийг хошууч генерал, агсан Ч.Данзан гэдэг. Миний хувьд буурал генералын барааг нэг хоёр удаа харснаас цаашгүй. Ямартаа ч туулсан замнал, хийсэн бүтээснээрээ бол өнөөдөр бие нь үгүй ч, нэр нь нэрэмжит байх тавилантай хүн гэж сэтгүүлчийн хувьд бодож явсаар олон жилийг үдэжээ. Тийм учраас "Барилгын" гэсэн тодотголтой Зэвсэгт хүчний 338 дугаар ангийг Ч.Данзан генералын нэрэмжит

болгоосой гэж хичээнгүйлэн хүсэх байна. Өчүүхэн миний бодлыг ус нутгийнхан нь болоод Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин ч дэмжих байх аа. Магадгүй энэ ажлыг өмнө нь сэдсэн хүмүүс байхыг үгүйсгэхгүй, тийм аваас дэм болоосой. 2016 онд буурал генералын мэндэлсний 100 жилийн ойг Монгол цэргийн музейд даруухан тэмдэглэн өнгөрүүлсэн юм. 2022 онд эрхэм генералын маань мэндэлсний нь 110 жилийн ой тохионо. Мөн онд 338 дугаар анги үүсэн байгуулагдсаныхаа 10 жилийн ойг тэмдэглэх юм билээ. "Хувьсгалын тохироо бүрдэнэ" гэж нэг яриа байдаг. Тэгээд ч хувьсгалын тохироо нэгэнт бүрдэж байгаа юм биш үү!!! Хэрвээ тийм бол олон хүний магнай тэнийж, унаган нутгийнх нь уул ус баясах байх даа. ТОДРУУЛГА: Хошууч генерал, агсан

Чимэдийн Данзан 1916 онд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутаг Хонгор багийн "Таван толгой" гэдэг газар төржээ. Тэр бээр 1937 онд цэргийн албанд мордож, 1939-1943 онд Тамсагбулагийн ҮИ Морьт дивизийн 15 дугаар Морьт хороонд Намын товчооны дарга, намын ажлын зааварлагчаар ажиллаж, Халхын голын болон Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин байв. Монголын Ардын Армийн Улс төрийн газрын дарга, Барилгын Цэргийн Ерөнхий Газрын Улс төрийн хэлтсийн дарга зэрэг өндөр албан тушаалд ажиллаж байсан, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн түүнд БНМАУ-ын СнЗ-ийн 1969 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 67 дугаар тогтоолоор хошууч генерал цол олгосон байна. **Бэлтгэл дэд хурандаа Гомбын БААТАРНУМ**

ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТЭЭ ХИЙН ЗААХ АРГЫН ЦУГЛАРАЛТАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагаагаа зохион байгуулж ангийн удирдлага, штабын офицерууд, салаа, салбарын захирагч нартай болон даргалах албан тушаалын ахлагч нартай явуулах заах аргын цугларалтыг 10 дугаар сарын 22, 25-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Энэ удаагийн заах аргын цугларалт нь "Цэргийн сургалт бэлтгэлийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, зохион байгуулах арга, хэлбэр" сэдвийн хүрээнд "Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн хэрэгжилтийг хангах" зорилго

дэвшүүлэн амжилттай зохин байгууллаа. Тус цугларалтын хүрээнд ХЗЦК-ын цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын дарга хурандаа Б.Эрдэнэпил хүрэлцэн ирж офицерын бүрэлдэхүүнтэй уулзаж цугларалтын үйл явцтай танилцсан. **Ахмад Л.Түмэндэлгэр**



40 НЭР ТӨРЛИЙН 70 ГАРУЙ НОМЫГ ХАНДИВЛАЛАА

ИБНАУ-д үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнээс Зэвсэгт хүчний Гадаад

хэлний сургалтын төвд цэргийн мэргэжлийн болон уран зохиолын 40 нэр төрлийн 70 гаруй номыг хандивлалаа. Энэхүү хандивын зорилго нь англи хэл

суралцагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, Гадаад хэлний сургалтын төвийн номын сан хөмрөгийг баяжуулахад чиглэгджээ.

